



МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2021 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.14 дэх хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн бус байгууллага сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт, хөндлөнгийн хяналт хийх журам”-ын хоёрдугаар бүлэгт дор дурдсан агуулгатай 2.1.5 дахь заалтыг нэмсүгэй.

“2.1.5.хөндлөнгийн хяналт, ажиглалт хийхээр төлөвлөж буй байршлын талаарх мэдээлэл.”


2. Мөн журмын 2.4 дэх хэсгийг “Сонгуулийн ерөнхий хороо сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт, хөндлөнгийн хяналт хийх хүсэлтийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор ажиглалт хийх байгууллагыг бүртгэх эсэх асуудлыг шийдвэрлэх ба энэ журмын 2.2-т зааснаар нэмэлт тайлбар, баримт бичиг гаргуулан авсан нь хүсэлт шийдвэрлэх хугацааг сунгах үндэслэл болохгүй.” гэж, 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийг “Төрийн бус байгууллага, түүний ажилтан нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд оролцохыг хориглоно.” гэж тус тус өөрчлөн найруулсугай.

3. Мөн журмын 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсгийн “болгох ба сонгуулийн тухай болон холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэснийг “болгон нийтэд мэдээлнэ.” гэж, 2 дугаар бүлгийн “2.3, 2.4” гэсэн дугаарыг “2.2, 2.3” гэж тус тус өөрчилсүгэй.

4. Мөн журмын 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсгийг, 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсгийн “санал хураалт дууссанаас хойш 30 хоногийн дотор” гэснийг тус тус хассугай.

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



П.ДЭЛГЭРНАРАН

Д.ДАВАА-ОЧИР

00000031